



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

200.1 онд 12 дугаар
сарын 13 өдөр

Дугаар 582

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөлийг
шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3, 7 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 1998 оны 186 дугаар тогтсолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах салбар зөвлөл"-ийг шинэчилж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр дүрмийг хоёрдугаар, хортой, бага хортой химийн бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд зөншөөрөл олгох журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн бодисыг цуглуулан устгах нэгдсэн цэгийн байршлыг Сонгино хайрхан дүүргийн нутаг баруун турууны хойт талд Тахир соёотын нурууны баруун урд ам, Улаанбаатар – Дарханы чиглэлийн авто замын зүүн талд 2.2 га –аар тогтоосугай.

3. Химийн бодисын хаягдал устгах талбайг барих зураг түүнийг байгуулахаар төлөвлөсөн хөрөнгийг 2002 оны хотын төсөвт тусгахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтэс / Д.Ганболд /-т, зургийн дагуу бариулахыг Хөрөнгө оруулалтын газар / Г.Өлзий /-т, зохих журмын дагуу химийн бодисыг устгахад хяналт тавихыг Байгаль орчин, экологийн хяналтын газар / Г.Бүдратчаа / Эрүүл мэндийн газар / Ц.Ганхүү /-т, химийн хорт бодисын үйл ажиллагааг зохицуулах орон тооны бус салбар Зөвлөл -ийг дүүргүүдэд байгуулж, аж ахуйн нэгж байгууллагуудад химийн хорт бодисоос хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Нийслэлийн нутаг дэвсгэрт химийн хорт бодистой холбогдсон үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих түүнийг хэрэгжүүлэх талаар дүрмэндээ заагдсан үүргийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг салбар зөвлөлийн орлогч дарга / Л.Доржсүрэн /-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1998 оны а/ 222 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



215

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 582 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах срон тооны бус Зөвлөл" –ийн бүрэлдэхүүн

Орлогч дарга

- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг,иргэний хамгаалалтын штабын дарга Байнгын онцгой комиссын үйлдвэрийн осол, хөнөөх үйлчилгээтэй хорт бодисын алдагдлаас сэргийлэх ажлын хэсгийн дарга

- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин,экологийн хяналтын газрын дарга,Байнгын онцгой комиссын гишүүн

Нарийн бичгийн дарга

- Цэрэг,иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтан, иргэний хамгаалалтын улсын ахлах байцаагч

Гишүүдэд

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого,төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан

- Нийслэлийн Байгаль орчин,экологийн хяналтын газрын химийн бодис хариуцсан ажилтан улсын байцаагч

- Эрүүл мэндийн хяналтын албаны эрүүл ахуйч их эмч,улсын байцаагч

- Хөдөлмөр нийгмийн хамгаалалын албаны хөдөлмөрийн эрүүл ахуй хариуцсан байцаагч

- МУИС – ийн шинэ материалын хими, технологийн төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

- "Тулга" компанийн гүйцэтгэх захирал



Нийслэлийн Засаг даргын 2001 оны 582 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХИМИЙН ХОРТ БОДИС АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл :

1. Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах салбар зөвлөл / цаашид "зөвлөл" гэнэ / нь Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, Монгол улс нэгдэн орсон химийн чиглэлийн олон улсын Конвенциуд болон химийн аюулгүй байдлыг хангах бусад бодлогыг төрийн захиргааны төв байгууллагуудаас хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэ дүрмийг дагаж мөрдөнө. Салбар зөвлөл орон тооны бус байна.
2. Зөвлөл нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллах бөгөөд дүүргийн Засаг даргын дэргэд салбар зөвлөлтэй байна.
3. Нийслэлийн зөвлөлийн дарга нь нийслэлийн Засаг дарга, дүүргийн салбар зөвлөлийн дарга нь дүүргийн Засаг дарга байна.
4. Зөвлөл нь нутаг дэвсгэрийн шинж чанартай ажиллах бөгөөд түүний бүрэлдэхүүнд холбогдох газар, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагын зохих албан тушаалтан, химийн мэргэжлийн хүмүүс орсон байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох газар, нэгж байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зөвлөлийн дарга томилно.
5. Зөвлөл нь бодлого, зохицуулалт хариуцсан болон хяналтын асуудал хариуцсан хоёр орлогч даргатай байна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Цэрэг, иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтан, иргэний хамгаалалтын улсын ахлах байцаагч, дүүргийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэрэг, иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтан, иргэний хамгаалалтын улсын байцаагч байна.
6. Зөвлөл 7 доошгүй, салбар зөвлөл 5 доошгүй гишүүдээс бүрдэнэ.
7. Шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн гишүүдэд зөвлөлийн дарга, дүүргийн Засаг даргын гарын үсэгтэй үнэмлэх олгож болно.
8. Зөвлөл нь Монгол улсын нэгдэн орсон химийн чиглэлийн олон улсын конвенциэр манай талын хүлээсэн үүрэг, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, иргэдийг мэдээллээр хангах ажлыг хариуцна.
9. Зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэх байгууллага холбогдох материалаа зөвлөлийн нарийн бичгийн даргад өгнө. Хурлын материалыг хурал болохоос 5 хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд тараана. Зөвлөлийн хурлыг шаардлагатай үед олонхийн ирцтэй хийнэ. Хуралдааныг зөвлөлийн дарга

28

удирдах бөгөөд түүний эзгүйд орлогчид удирдаж, хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, зөвлөмж гаргана. Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, бодлого зохицуулалт хариуцсан орлогч даргаар гарын үсэг зуруулан тэмдэг дарж баталгаажуулна.

10. Зөвлөл нь хууль тогтоомжийн дагуу нийслэлийн хэмжээнд мэргэжлийн санал дүгнэлт гаргахдаа тухайн орон нутагт байгаа мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, мөн ажлын хэсэг байгуулан ажиллуулна.

11. Зөвлөл нь нийслэлийн төр, захиргааны байгууллагын хэвлэмэл хуудас, тэмдэгийг хэрэглэнэ.

12. Зөвлөл гишүүдэд хуралд оролцсон байдал, идэвхи санаачлага, ажлын үр дүнг харгалзан урамшуулал, ажлын хөлс олгоно. Зөвлөлийн санхүүжилтийн асуудлыг зөвлөлийн дарга зохицуулан шийдвэрлэнэ.

Хоёр. Зөвлөлийн үүрэг, бүрэн эрх

Зөвлөл нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ.

1. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж, түүнийг боловсронгуй болгон өөрчлөхөд санал дүгнэлт гаргах, холбогдох асуудлаар мэргэжлийн зөвлөмж гаргах.

2. Химийн хорт бодисоос хамгаалах түүнийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих.

3. Монгол улсын нууцын зэрэглэлийн шаардлага зөрчихгүйгээр нийслэл, дүүргийн хэмжээнд хэрэглэж байгаа химийн хорт бодисын ашиглалт, зарцуулалтын тайлан гаргах, тооллого явуулах, бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

4. Химийн хорт бодистой харьцан ажиллагсдын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах, иргэдийг химийн бодисоос хамгаалах асуудлаар төрөл бүрийн сургалт сурталчилгаа зохион байгуулах.

5. Монгол Улсын хилээр нэвтэрч нийслэлийн нутаг дэвсгэрт орж байгаа химийн бодисын талаархи мэдээллийг гаалийн байгууллагаар гаргуулан авч, дүгнэлт хийх үндсэн дээр нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийг химийн бодисын тухай мэдээллээр хангах.

6. Нийслэлийн хэмжээнд хортой, бага хортой химийн бодисыг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, хэрэглэх, устгах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон асуудлаар зөвшөөрөл олгохыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дүгнэлт гаргах.

7. Химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар салбар зөвлөлийн арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх нэгдсэн бодлого, удирдлагаар хангах.

8. Монгол улсын нэгдэн орсон химийн чиглэлийн олон улсын Конвенциудыг хэрэгжүүлэхэд Монголын талын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, энэ талаар холбогдох санал зөвлөмж боловсруулах

9. Салбар зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах

Зөвлөл нь дараахь эрхийг хэрэгжүүлнэ:

1. Химийн хорт бодисын асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, хяналт тавих хэсэг байгуулахад холбогдох мэргэжилтэн, шинжээч, улсын байцаагчдыг татан оролцуулах

2. Энэ дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээ тайлан судалгааг гаргуулан авах

3. Химийн хорт бодис ашиглаж байгаа байдалд шалгалт тооллого, ажлын зураг авалт хийх, шинжилгээний сорьц авах ажлаар зөвлөлийн гишүүд аж ахуйн нэгж, үйлдвэр, байгууллагад чөлөөтэй нэвтрэх

4. Эрх бүхий байгууллагаас хортой, бага хортой химийн бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах, хэрэглэх, устгах зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж нэгж байгууллагад дүгнэлт гаргаж өгөх



Нийслэлийн Засаг даргын 2001 оны 582 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

**ХОРТОЙ БАГА ХОРТОЙ ХИМИЙН БОДИСЫГ ХИМИЙН
БОДИСЫГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХЭД
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ.**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3.7 дугаар зүйлийн 2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2001 оны 54 дугаар тогтоол, Байгаль орчны сайд, Хөдөө аж ахуй үйлдвэрийн сайдын 1998 оны 86 /А /120 дугаар хамтарсан тушаалд заасны дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн Засаг даргын хяналтын дор улсын хилээр нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан химийн бодист импортын зөвшөөрөл олгоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах салбар зөвлөл / цаашид зөвлөл гэнэ / -ийн дүгнэлтийг нийслэлийн Засаг даргад танилцуулж, түүнийг зөвшөөрсний үндсэн дээр Зөвшөөрөлд нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, Цэрэг, иргэний хамгаалалтын иргэний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтан нар гарын үсгээ зурж тэмдэг дарна.

1.3. Химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлох, худалдах, ашиглах, зөвшөөрөл олгоход Байгаль орчны сайд, Хөдөө аж ахуй үйлдвэрийн сайдын 1998 оны 86/А/120 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан маягтыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Зөвшөөрөл олгох, өргөдөл гаргах,
хянан шийдвэрлэх.**

2.1 Улсын хилээр химийн бодис импортлох зөвшөөрөл хүсэгч нийслэлийн нутагт үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж өргөдлөө нийслэлийн Засаг даргын дэргэдэх химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлд гаргана. Өргөдөлд дор дурьдсан зүйлийг заасан байвал зохино. Үүнд:

- өргөдөл гаргагчийн нэр хаяг
- химийн бодисын нэр, тодорхойлолт, уяалдуулсан системийн код
- Бодисын тоо хэмжээ, чөлөөт валютаар илэрхийлсэн үнэ
- нийлүүлэх хугацаа, тээврийн төрөл
- гадаад орны экспортлогчийн нэр хаяг

- барааны гарал үүслийн орон
- бараа нийлүүлэх Монгол улсын хилийн боомтын нэр
- өргөдөл гаргагчийн харъяалагдах татварын албаны нэр, хаяг

өргөдөлд дурьдсан мэдээллийн үнэн зөвийн хариуцлагыг өргөдөл гаргагч хүлээнэ.

2.2.Экспорт, импортын зөвшөөрөл олгох өргөдөлд дор дурьдсан материалыг хавсаргасан байна

- аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- иргэний хувьд иргэний үнэмлэхийн наториатчаар гэрчлүүлсэн хуулбар
- гэрээ контрактын хуулбар

2.3. Зөвлөл химийн бодисыг импортлох зөвшөөрөл олгох тухай өргөдөл, зохих журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1 - 2 өдөрт багтаан дүгнэлт гаргана.

2.4. Шаардлагатай бол зөвлөл өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 2-3 хоногоор сунгаж болно.

2.5.Зөвшөөрлийг батлагдсан маягтын маягтын дагуу 2 хувь үйлдэнэ.

Гурав. Бусад асуудал

3.1.Зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

3.2. Зөвшөөрөлд нэр заасан барааны хадгалах, борлуулах, хугацааны шаардлага, тээвэрлэлт, хамгаалалтын чанар, стандартын нөхцлийг хангасан байх үүргийг зөвшөөрөл хүсэгч өөрөө хариуцана.

3.3. Зөвшөөрөл олгосон тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж Үйлдвэр худалдааны яаманд хүргүүлнэ.

3.4.Зөвшөөрөл хүсэгч зөвшөөрөл олгохтой холбогдсон асуудлаархи нийслэлийн Засаг даргын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргана.